МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2023.10.20 № 8/3516

танай ______ -ны № ______ -т

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН
ҮЙЛДВЭР, КОМПАНИУДЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл"-ийн хүрээнд Эрчим хүчний салбарын жендерийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлж, энэ ажлын хүрээнд салбарын хэмжээнд дөрвөн зорилтот аймгийн станц, түгээх сүлжээний холбогдох байгууллагуудыг түүвэрлэн сонгож эрчим хүчний салбар дах жендерийн нөхцөл байдлын үнэлгээний судалгааг хийн, тайланг хэлэлцүүлсэн.

Энэхүү тайланд үндэслэн Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх 2023-2032 он хүртэлх жендерийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, эрчим хүчний сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлуулаад байна.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт, үйл ажиллагааг жил бүр төлөвлөн, холбогдох арга хэмжээг авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр чиглэл болгож байна. (Стратеги төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлэв.)

Хавсралт 18 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ

17060000 4076

Сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны
өдрийн А/208 дугаар тушаалын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2023-2032 ОН/

| № | Зорилго, зорилт, үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021/2022 | 2023 | 2027 | 2032 | Үндсэн | Хамтрагч |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | **Зорилго 1.** **Салбарын удирдлага, ажилтанд жендэрийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлж, хэвшмэл үзлийг өөрчлөн, эрх тэгш байдлын тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлнэ.** | **Тухайн хугацааны төлөвлөгөөний хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ЭХЭЗХ, Сургагч багш, НЗБ, ТбХХ-ийн ААНБ** | **ЖҮХ, ЖҮХ-ны дэргэдэх ЖҮШБ, Эрдэмтэн судлаачдын бүлэг, МХ, ТББ** |
| 1.1 | **Зорилт 1.1.** **Салбарын удирдлага, ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх цогц үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.** | **Жил бүрийн төлөвлөгөөний хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ЭХЭЗХ, Сургагч багш, НЗБ, ТбХХ-ийн ААНБ** | **ЖҮХ, ЖҮХ-ны дэргэдэх ЖҮШБ, ЭСБ, ТББ** |
| 1.1.1 | **Үйл ажиллагаа 1.1.1** Яамнаас салбарын удирдлага, ажилтан, | Удирдамж | Тоо | 0 | 1 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЖСЗ, ЭХЭЗХ | ЖҮХ, ЖҮШБ, |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчид жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх үйл ажиллагааг явуулах удирдамж боловсруулж, төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-д хэрэгжүүлнэ. | Удирдамж хэрэгжүүлж байгаа ААНБ | Тоо | 0 | 308 | 308 | 308 | | ЭСБ, ЭХЗХ |
| 1.1.2 | **Үйл ажиллагаа 1.1.2** Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж нэвтрүүлнэ. | Сургалтын хөтөлбөр, модуль | Тоо | 0 | 1 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЖСЗ, ЭХЭЗХ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, ШУТИС, ЭХЗХ, МСҮТ, МХ, ТББ, ХБ |
| 1.1.3 | **Үйл ажиллагаа 1.1.3** Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан сургалт явуулах үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэнэ. | Салбарын сургагч багш | Тоо | 0 | 5 | 10 | | Эрчим хүчний яам, ЭХЭЗХ, ЭХҮТ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ШУТИС, СҮТ, ЖҮХ, ЖҮШБ, ЭХЗХ, ЭСБ, МХ, ТББ, ХБ |
| | | Орон нутгийн сургагч багш | Тоо | 0 | 0 | 0 | 28 | | |
| 1.1.4 | **Үйл ажиллагаа 1.1.4** Хүйсийн онцлог хэрэгцээг харгалзан чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт, давтан сургалтыг төлөвлөх үлгэрчилсэн загвар баталж, салбарын ААНБ-д хэрэгжүүлнэ. | Загвар | Тоо | 0 | 1 | | | Эрчим хүчний яам, ЭХЭЗХ, ЭХҮТ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ЭСБ, МХ, ЭХЗХ,ТББ, ХО, ХБ, |
| | | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 0 | 28 | 42 | 60 | | |
| 1.1.5 | **Үйл ажиллагаа 1.1.5** Салбарын инженер, техникийн ажилтан бэлтгэх дээд боловсролын, техникийн, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр болон мэргэжлийн зэрэг олгох, ахиулах сургалтын хөтөлбөрт жендэрийн агуулга бүхий сургалтын модуль боловсруулж, мэргэжсэн багшийг бэлтгэнэ. | Сургалтын модуль | Тоо | 0 | 1 | 2 | | Эрчим хүчний яам, ШУТИС- ЭХС, ТМБСБ, ЭХҮТ-СҮТ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ |
| | | Бэлтгэсэн багш | Тоо | 0 | 2 | 4 | | | |
| 1.1.6 | **Үйл ажиллагаа 1.1.6** | Сургалтын хөтөлбөр | Тоо | 0 | 1 | | | | ЖҮХ, ЖҮШБ, |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр (цахим болон танхимын) боловсруулж, сургалтыг тогтмол явуулна. | Сургалтад хамрагдсан УАТ | Хувь | | 10 | 50 | 40 | Эрчим хүчний яам, ТАЗ, УА, ТбХХ-ийн ААНБ | ЭСБ, МХ, ТББ, ХО, ХБ |
| 1.1.7 | **Үйл ажиллагаа 1.1.7**<br>Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтыг тогтмол зохион байгуулна. | Сургалт зохион байгуулдаг ААНБ | Тоо | 0 | 10 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, МХ, ТББ, ХО, ХБ |
| **1.2** | **Зорилт 1.2. Салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлнэ.** | **Жил бүрийн төлөвлөгөөний хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ** | **ЖҮХ, МХ, ТББ** |
| 1.2.1 | **Үйл ажиллагаа 1.2.1**<br>Салбарын жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг ААНБ, ИНБ-ын төлөөллөөр өргөтгөн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж, удирдамжаар хангах, яамны бодлого төлөвлөлтийн нэгжид жендэрийн орон тооны мэргэжилтэн, төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААНБ-д жендэрийн асуудал хариуцсан ажилтан ажиллуулна. | Ажил үүргийн хуваарь | Тоо | 0 | 1 | | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МХ, ТББ |
| | | Орон тооны мэргэжилтэн | Тоо | 0 | 1 | | | | |
| | | Хариуцсан ажилтантай ААНБ | Тоо | 0 | 26 | 42 | 60 | | |
| 1.2.2 | **Үйл ажиллагаа 1.2.2**<br>Салбарын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг жендэрийн дүн шинжилгээ хийх дунд шатны сургалтад хамруулж, мэргэшүүлэх | Хамрагдсан орон тооны мэргэжилтэн | Тоо | | 1 | | | Эрчим хүчний яам | ТАЗ, ЖҮХ |
| 1.2.3 | **Үйл ажиллагаа 1.2.3**<br>Салбарын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, | Шинэчлэн батлагдсан албан | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам | ТАЗ, ЖҮХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөвлөлтийн шатанд жендэрийн мэргэжилтнийг дэмжиж ажиллах ажилтныг тодорхойлж, жендэрийн чиг үүргийг нь албан тушаалын тодорхойлолтод тусгана. | тушаалын тодорхойлолт | | | | | | | |
| 1.2.4 | **Үйл ажиллагаа 1.2.4**<br>Салбарын бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хүний нөөц, худалдан авах ажиллагаа, дотоод аудитын мэргэжилтнүүдийг жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагааг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх зэрэг чадавх бэхжүүлэх сургалтад хамруулна. | Сургалтад хамрагдсан мэргэжилтэн, хүйсээр | Тоо | 0 | 6 | 28 | 46 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, УА |
| 1.2.5 | **Үйл ажиллагаа 1.2.5**<br>Салбарын хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистикийг өргөжүүлэн, судалгаа, бусад мэдлэгийн бүтээгдэхүүний цахим сан байгуулж, ашиглалтыг хангана. | Цахим сан | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ДҮТ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, МХ, ТББ, ХО, ХБ |
| | | Мэдээлэл ашигласан ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 60 | | |
| 1.2.6 | **Үйл ажиллагаа 1.2.6**<br>Эрчим хүчний бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд жендэрийн дүн шинжилгээ хийх шалгах хуудас боловсруулан, хэрэгжүүлнэ. | Шалгах хуудас | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ | МХ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ, ХО, ХБ, ОУБ |
| 1.2.7 | **Үйл ажиллагаа 1.2.7**<br>Жендэрийн стратегид нийцүүлэн шинэчлэх бодлогын баримт бичиг, хууль, эрх зүйн акт, дагалдах маягт зааврын жагсаалт гаргаж, нэмэлт өөрчлөлт оруулна. | Жагсаалт | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, МХ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ, ХО, ХБ |
| | | Шинэчилсэн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг | Хувь | 0 | 0 | 30 | 70 | | |
| 1.2.8 | **Үйл ажиллагаа 1.2.8**<br>ХШҮ-ний тогтолцоонд хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн шалгуур үзүүлэлт ашиглах жендэрийн мэдрэмжтэй аргачлал боловсруулж, хэрэгжүүлнэ. | Аргачлал | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | МХБ, ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, МХ, ТББ, НЗБ, ХО, ХБ |
| | | Нэвтрүүлсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 42 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.9 | **Үйл ажиллагаа 1.2.9** Салбарын онцлогт нийцүүлсэн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүй, аргачлал боловсруулан нэвтрүүлж, хэрэгжилтийг хангана. | Аргачлал | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МХ, ТББ, ХБ |
| | | Аргачлал нэвтрүүлсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 42 | | |
| | | Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөсөн санхүүжилтийн өсөлт | Хувь | | 10 | 20 | 30 | | |
| 1.2.10 | **Үйл ажиллагаа 1.2.10** Салбарын ААНБ-ын шийдвэр гаргах бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох удирдамж гарган мөрдүүлнэ. | Удирдамж | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, Үндэсний сургагч багш | ЖҮХ, МХ, ТББ |
| | | Удирдамж хэрэгжүүлж буй ААНБ | Тоо | 0 | 0 | 26 | 42 | | |
| 1.2.11 | **Үйл ажиллагаа 1.2.11** Жил бүр жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний төсвийг батлан, хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн ААНБ-ыг урамшуулна. | Урамшуулах шалгуур үзүүлэлт | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам | ТББ, МҮЭХ, ХМБ, ХО, ХБ |
| | | Урамшуулсан ААНБ | Тоо | 0 | 0 | Жил тутам 3 | Жил тутам 5 | | |
| 1.2.12 | **Үйл ажиллагаа 1.2.12** Салбарын ААНБ жендэрийн эрх тэгш байдлыг хангах тодорхой ажлыг ТББ-аар гүйцэтгүүлэхээр төлөвлөж, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгана. | Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил | Тоо | 2 | 4 | 12 | 24 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ОУБ |
| | | Төсөвт зардлын өсөлт | Хувь | | 10 | 15 | 20 | | |
| 1.2.13 | **Үйл ажиллагаа 1.2.13** Олон улсын байгууллага, хөгжлийн түншүүдийн санхүүжилтээр салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийн сан бий болгож, салбарт хэрэгжих төсөл хөтөлбөр, зээл тусламжийн тодорхой хувийг жендэрийн стратегийг тогтвортой хэрэгжүүлэхэд зарцуулдаг болно. | Мэдээллийн сан | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам | ЖҮХ, Хөрөнгө оруулагч, Хандивлагч байгууллага, Мэргэжлийн холбоод |
| | | ЖС-ийн хэрэгжилтэд зарцуулсан төсөл, хөтөлбөрийн төсвийн өсөлт | Хувь | | | 15 | 35 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2** | **Зорилго 2. Салбарын ААНБ-ын удирдах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн мэдрэмжтэй орчин нөхцөл бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | **Тухайн хугацаанд зорилтот түвшин, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ, НЗБ** | **ЖҮХ, ТАЗ, МҮЭХ, МХ, ТББ** |
| **2.1** | **Зорилт 2.1. Салбарын ААНБ-ын шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангана.** | **Тухайн хугацаанд зорилтот түвшинг хангасан байдал** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ** | **ЖҮХ, ТАЗ, МҮЭХ, МХ, ТББ** |
| 2.1.1 | **Үйл ажиллагаа 2.1.1** Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах түвшинд аль нэг хүйсийн оролцоо, төлөөллийг хангах зорилтот түвшинг тодорхойлж, хэрэгжүүлнэ. | Тодорхойлсон зорилтот түвшин | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МҮЭХ, МХ, ТББ, |
| | | Зорилтот түвшинд хүрсэн ААНБ | Хувь | 0 | 0 | 30 | 50 | | |
| 2.1.2 | **Үйл ажиллагаа 2.1.2** Төрийн удирдах албан тушаалтан, төрийн ба төсөвт байгууллагын түвшинд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар тогтоосон квотыг хэрэгжүүлнэ. | Квотын хэрэгжилт хувиар | Хувь | | | 40 | 60 | ЭХЯ, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МХ, ШУТИС, МСҮТ |
| 2.1.3 | **Үйл ажиллагаа 2.1.3** Сайд, ТНБД-ын шийдвэрээр байгуулсан болон үндэсний хэмжээний хороо зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнд хүйсийн 40:60 харьцааг хангана. | Хангасан хувь | Хувь | 5% | 20% | 40% | | Эрчим хүчний яам | ТАЗ |
| 2.1.4 | **Үйл ажиллагаа 2.1.4** Салбарын эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах холбоо байгуулан ажиллах санаачилгыг дэмжинэ. | Хамрагдсан эмэгтэйчүүд | Хувь | 0 | 30 | 60 | 90 | Эмэгтэй ажилтнууд | ЭХЯ, МХ, ҮЭ |
| 2.1.5 | **Үйл ажиллагаа 2.1.5** | Хөтөлбөр | Тоо | 0 | 0 | 1 | | | Салбарын эмэгтэйчүүдийн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Салбарын ААНБ-ын удирдах албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийг бэлтгэх, чадавхжуулах, дагалдуулан сургах зэрэг чиглэлээр “Эрчим хүчний салбарын эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр” хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт | Хувь | 0 | 20 | 50 | 100 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ | холбоо, МХ, ШУТИС, УА, ТАЗ, ЖҮХ, ОУБ |
| 2.1.6 | **Үйл ажиллагаа 2.1.6**<br>Зөвлөх, мэргэшсэн инженер, тэргүүлэх төсөвчний зэрэг дэв горилж буй эмэгтэй ажилтанд ажлын байран дээр суралцуулах, цалинтай чөлөө олгох, туршлагатай ажилтныг дагалдуулан сургах, сургалтын төлбөр, зардлын тэтгэлэг олгох, байгууллага квот тогтоох зэрэг дэмжлэгийг хэрэгцээнд нь нийцүүлэн үзүүлнэ. | Дэмжлэгт хамрагдсан эмэгтэйчүү дийн өсөлт | Хувь | | 10 | 20 | 30 | ЭХЯ, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, ШУТИС, УА | ТАЗ, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, ЖҮХ, ОУБ |
| 2.1.7 | **Үйл ажиллагаа 2.1.7**<br>ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүнээр ажиллах эмэгтэйчүүдийн чадавхыг дээшлүүлж, оролцоог нэмэгдүүлнэ. | Хамрагдсан эмэгтэйчүү дийн өсөлт | Хувь | 0 | 10 | 20 | 30 | Эрчим хүчний яам, ТбХХ-ийн ААНБ, МХ, ТББ | Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, ЖҮХ, ОУБ |
| 2.1.8 | **Үйл ажиллагаа 2.1.8**<br>ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн, урамшууллын хэмжээг хүйсээр ангилан судалж, ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүний төлөөлөлд хүйсийн тэнцвэрийг харгалзах, хараат бус гишүүнд хэрэглэгч/ үйлчлүүлэгчийн төлөөлөл, салбарын мэргэжлийн холбоод, ИНБ-ыг нэр дэвшүүлэх, хараат бусаар сонгон шалгаруулах, ил тод байдлыг хангахаар компанийн дүрэмд тусгаж хэрэгжүүлнэ. | Хүйсээр ангилсан мэдээлэл | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ТбХХ-ийн ААНБ, МХ, ТББ | Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, ЖҮХ, ОУБ |
| | | Шалгуур | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Дүрмийн шинэчлэл | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Бүрэлдэхүүнд хүйсийн өөрчлөлт гаргасан ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 42 | | |
| **2.2** | **Зорилт 2.2. Салбарын төрийн болон хувийн хэвшлийн бүх ААНБ-ын ажилтанд жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин нөхцөл бүрдүүлэх, эрэгтэй,** | **Тухайн хугацааны төлөвлөгөө ний хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МҮЭХ, ТбХХ-ийн ААНБ** | **ЖҮХ, ТАЗ** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **эмэгтэйчүүд тэгш үр шим хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 2.2.1 | **Үйл ажиллагаа 2.2.1** Салбарын түвшинд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг жендэрийн агуулгатай хийж, хэвийн бус ажлын байрны жагсаалтын ангиллыг шинэчлэн, хэвийн бус хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргана. | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| | | Жагсаалт, ангилал | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Зөвлөмж | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| 2.2.2 | **Үйл ажиллагаа 2.2.2** Инноваци, техник технологийн дэвшлийг ажлын байранд нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих, энэ чиглэлд олон улсын туршлагыг судлан, эмэгтэйчүүдийн ажиллах боломжийг нэмэгдүүлж, ажлын орчны өөрчлөлтийг үе шаттай хийн, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвлөж зарцуулна. | Салбар дахь эмэгтэй ажилтны хувийн жингийн өсөлт | Хувь | 0 | 0 | 3 | 5 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХБ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | ЭШБ, МҮЭХ, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| 2.2.3 | **Үйл ажиллагаа 2.2.3** Салбарын түвшинд ажлын байрны эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэгийг жендэрийн мэдрэмжтэй явуулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Үнэлгээ | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, МХАЭБ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МҮЭХ, МХ, ТББ, ХО |
| | | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 8 | 8 | 28 | 40 | | |
| 2.2.4 | **Үйл ажиллагаа 2.2.4** Эрэгтэй ажилтны дундаж наслалтын судалгааг гаргаж, нөлөөллийн хүчин зүйлсийг илрүүлж, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх (эрүүл хоол хүнс хэрэглэх, хорт зуршил, стрессийг арилгах) зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлнэ. | Судалгаа | Тоо | 0 | 0 | 0 | 0 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, МЭрХолбоо, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| | | Зөвлөмж | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 40 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.5 | **Үйл ажиллагаа 2.2.5**<br>Салбарын эрэгтэйчүүдийн дунд стресс тайлах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, зөв үлгэр дуурайлал түгээх арга хэмжээг спорт, урлагийн зэрэг сонирхлын клуб, бүлэгт нэвтрүүлж, дэмжинэ. | Сонирхлын клуб, бүлгийг дэмжсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 40 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, БТСУХ, СУГ, ГБХЗХГ, МЭрХолбоо, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| 2.2.6 | **Үйл ажиллагаа 2.2.6**<br>Эрэгтэйчүүдэд чанартай урт наслах, эрүүл чийрэг амьдрах, хорт зуршлаас ангижрах хүсэл эрмэлзэл төрүүлж, идэвхжүүлэх үүднээс амьдралын зөв дадал хэвшилтэй, бусдад үлгэр дууриалал болохуйц салбарын шилдэг эрэгтэйчүүдийг алдаршуулж, урамшуулна. | Шилдэг эрэгтэйчүүдийг алдаршуулж, урамшуулсан ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 40 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, БТСУХ, СУГ, ГБХЗХГ, МЭрХолбоо, ХМЗ, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| 2.2.7 | **Үйл ажиллагаа 2.2.7**<br>Эрэгтэйчүүдийн дундаж насжилтыг нэмэгдүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослын эрсдлээс хамгаалах хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, арга хэмжээний тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | Хөтөлбөр | Тоо | 0 | 0 | 1 | 0 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, БТСУХ, СУГ, ГБХЗХГ, ХМЗ, МЭрХолбоо, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| | | Хэрэгжилт | Хувь | 0 | 0 | 40 | 60 | | |
| 2.2.8 | **Үйл ажиллагаа 2.2.8**<br>ЖЭТБХ тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид ногдуулсан үүргийн хэрэгжилтийг хангуулж, ААНБ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилнэ. | ХДЖ-аа шинэчилсэн ААНБ | Тоо | 2 | 40 | 60 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |
| 2.2.9 | **Үйл ажиллагаа 2.2.9**<br>Ажилтны нийгмийн баталгааг хангах бодлого, арга хэмжээг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 2 | 40 | 60 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, МХАЭБ, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, Салбарын эмэгтэйчүүдийн холбоо, МЭрХолбоо, МХ, ТББ, ЖҮХ, ХО |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.10 | **Үйл ажиллагаа 2.2.10** Салбарын ААНБ ажлын байрны үнэлгээг хийж, ижил ажилд адил цалин хөлс олгохоор цалин хөлсний тогтолцоог жендэрийн мэдрэмжтэйгээр шинэчилнэ. | Үнэлгээ хийсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 0 | 28 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, МХАЭБ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МҮЭ, МХ, ТББ, ХО, |
| 2.2.11 | **Үйл ажиллагаа 2.2.11** Ажлын байрны үнэлгээний тайлан дүгнэлтэд тулгуурлан жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй зэрэг эмэгтэйчүүд ажиллахад тохиромжгүй ажлын байрыг тодорхойлж, эрх зүйн актад тусган, ажлын байранд тэгш ажиллах боломжийг бүрдүүлнэ. | Батлагдсан эрх зүйн акт | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, МХАЭБ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МҮЭ, МХ, ТББ, ХО, |
| 2.2.12 | **Үйл ажиллагаа 2.2.12** Салбарын ААНБ-ын дотоод журамд хамтын/ тарифын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн маргааны талаарх гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизмыг жендэрийн мэдрэмжтэй болгоно. | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, МҮЭХ, ХЭҮК, МХ, ТББ, ХО |
| 2.2.13 | **Үйл ажиллагаа 2.2.13** Ажилтны ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин нөхцөл бүрдүүлэх стратеги, хүүхэд хамгааллын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. | Стратеги, бодлого | Тоо | 0 | 2 | | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, ЖҮХ, ГБХЗХГ, МХ, ТББ, ХО, ХБ |
| | | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 2 | 28 | 42 | 60 | | |
| 2.2.14 | **Үйл ажиллагаа 2.2.14** Жирэмсэн, хөхүүл, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах боломж бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлнэ. | Сайн туршлага нэвтрүүлсэн ААНБ | Тоо | | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, ГБХЗХГ, ЖҮХ, МХ, ТББ, ХО, ХБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.15 | **Үйл ажиллагаа 2.2.15** 12 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, өрх толгойлсон эрэгтэйчүүдэд зориулан гэр бүлдээ зарцуулах цагийг уртасгах боломжийг бүрдүүлэх, сайн туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ. | Сайн туршлага нэвтрүүлсэн ААНБ | Тоо | | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, ГБХЗХГ, МЭрХолбоо, ЖҮХ, МХ, ТББ, ХО, ХБ |
| 2.2.16 | **Үйл ажиллагаа 2.2.16** 18 хүртэлх насны хүүхэдтэй ажилтанд чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрүүл өсөж бойжих эрхийг хангах, энэ талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, гэр бүлийн боловсрол олгох зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. | зорилтот хөтөлбөр ААНБ | Тоо | | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, НУБ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, ГБХЗХГ, ЖҮХ, МХ, ТББ, ХО, ХБ |
| 2.2.17 | **Үйл ажиллагаа 2.2.17** Жендэрийн мэдрэмжтэй мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг ЕБС болон салбарын ахмадуудтай хамтран хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 60 | Эрчим хүчний яам | ЖҮХ, ЕБС, МАхХ |
| 2.2.18 | **Үйл ажиллагаа 2.2.18** Салбарын хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулж, инженер техникийн ажилтан, мэргэжилтний тухайн салбарт эзлэх хүйсийн зохистой хувь хэмжээг салбарын онцлогт нийцүүлэн тогтоож, ШУТИС, МСҮТ-ийн элсэлтийн бодлогод хүйсийн квотын тусгай арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ. | Салбарын хүний нөөцийн ХАМ-ийн сан | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, ШУТИС, МСҮТ | ЖҮХ, ЭСБ, НУБ, МХ, ТББ, Хөдөлмөрийн бирж |
| | | | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Тогтоосон квот | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| | | Элсэгчдийн хүйсийн мэдээлэл | Тоо | 0 | 0 | 1 | | | |
| 2.2.19 | **Үйл ажиллагаа 2.2.19** Өндөр насны тэтгэвэрт гарах эрхийн хэрэгжилтэд гарч буй зөрчлийг арилгах арга хэмжээг Хөдөлмөрийн тухай хууль, ЖЭТБХ тухай хуульд нийцүүлэн ААНБ-ын эрх зүйн баримт бичигт тусган, Ахмад настныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 0 | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | МҮЭХ, МАхХ, АОМХ, ТББ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 2.2.20 | **Үйл ажиллагаа 2.2.20** ТӨХК-ийн ажилтанд олгох урамшуулал дэмжлэгт жендэрийн дүн шинжилгээ хийж, нэмэгдүүлэх чиглэл, арга хэмжээг хамтын гэрээ/ тарифын хэлэлцээрт тусгана. | Тусгасан гэрээ/ хэлэлцээр | Тоо | 0 | 0 | 1 | 2 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ | МҮЭХ, АОМХ, ТББ |
| 2.2.21 | **Үйл ажиллагаа 2.2.21** Салбарын ААНБ-д хүүхдийн өрөө байгуулах, хүүхдийн цэцэрлэг ажиллуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ. | Байгууллагын дэргэдэх цэцэрлэг | Тоо | 0 | 0 | 14 | 28 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ | Бүх шатны ИТХ, Засаг дарга |
| 2.2.22 | **Үйл ажиллагаа 2.2.22** Салбарын ААНБ-д сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээг тодруулан, мэргэжлийн байгууллагаар хөтөлбөр гаргуулж, мэргэжсэн зөвлөх үйлчилгээ авах боломжийг хангана. | Зөвлөх үйлчилгээ авсан ААНБ | Тоо | 0 | 0 | 14 | 28 | Эрчим хүчний яам, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ЖҮШБ, ЭСБ, МХ, ТББ, ХБ |
| **2.3** | **Зорилт 2.3. Салбарт жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллийг арилгах бодлого, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.** | **Тухайн хугацааны төлөвлөлтийн хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ, НЗБ** | **ЖҮХ, ТББ, МҮЭХ** |
| 2.3.1 | **Үйл ажиллагаа 2.3.1** Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах бодлого, үйл ажиллагаа явуулах удирдамж батлан, салбарын ААНБ-д төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. | Удирдамж | Тоо | 0 | 1 | | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ, НЗБ | ЖҮХ, ТББ, МҮЭХ |
| | | Төлөвлөгөө хэрэгжүүлж буй ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 42 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2 | **Үйл ажиллагаа 2.3.2** ААНБ төлөвлөгөөний дагуу, ажлын байрны бэлгийн дарамт болон бусад дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулна. | Сургалтын хөтөлбөр | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ТББ, МҮЭХ |
| | | Сургалт зохион байгуулдаг ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 60 | | |
| 2.3.3 | **Үйл ажиллагаа 2.3.3** ААНБ хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байрны бэлгийн болон бусад дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг тусган нэвтрүүлнэ. | Механизм нэвтрүүлсэн ААНБ | Тоо | 0 | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ХЭҮК, ЖҮХ, МҮЭХ, МХ, ТББ, ХО |
| | | Салбарын хэмжээний гомдол, шийдвэрлэлтийн тайлан | Тоо | 0 | 1 | 4 | 5 | | |
| 2.3.4 | **Үйл ажиллагаа 2.3.4** Салбарын ААНБ бүрд ёс зүйн хороо байгуулж, мөрдөх дүрэм журмыг жендэрийн мэдрэмжтэй батлан мөрдүүлж, эрх нь зөрчигдсөн ажилтнуудыг хамгаалах тогтолцоог хөгжүүлнэ. | Жендэрийн мэдрэмжтэй байгуулагдсан Ёс зүйн хороотой ААНБ | Тоо | 0 | 28 | 42 | 60 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ХЭҮК, ЖҮХ, МҮЭХ, МХ, ТББ, ХО, ОУБ |
| 2.3.5 | **Үйл ажиллагаа 2.3.5** Салбарын ААНБ-ын удирдах албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан үйлдэлд дүн шинжилгээ хийж, арилгах асуудлыг бодлого, арга хэмжээнд тусгаж хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн ААНБ | Тоо | 0 | 0 | 28 | 42 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ТАЗ, МҮЭХ |
| **3** | **Зорилго 3. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад салбарын хувь нэмрийг нэмэгдүүлэх болон хэрэглэгчдэд үйлчлэх бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ.** | **Салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, НУБ** | **ЖҮХ, ОУБ** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1** | **Зорилт 3.1. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад эрчим хүчний салбарын хувь нэмрийг нэмэгдүүлэх жендэрийн мэдрэмжтэй арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | **Зорилтын тухайн хугацааны төлөвлөлтийн хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ** | **ЖҮХ** |
| 3.1.1 | **Үйл ажиллагаа 3.1.1** Ногоон хөгжлийн бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбарын хэмжээнд жендэрийн үнэлгээ хийж, зөвлөмж, сургалтын гарын авлагаар хангана. | Үнэлгээ, зөвлөмж, гарын авлага | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |
| 3.1.2 | **Үйл ажиллагаа 3.1.2** Эрчим хүч үйлдвэрлэлийн хүлэмжийн хийн ялгаруулалтад жендэрийн хүчин зүйлс, нөлөөллийн шинжилгээ хийж, холбогдох бодлогын баримт бичигт тусгана. | Бодлогын баримт бичгийн өөрчлөлт | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |
| 3.1.3 | **Үйл ажиллагаа 3.1.3** Барилгын дулаалга, шинэ техник технологи нэвтрүүлэх зэргээр эрчим хүчний хэмнэлт бий болгоход чиглэсэн нөлөөллийн ажлыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлнэ. | Нөлөөллийн төлөвлөгөө хэрэгжүүлж буй Үүрэг хүлээсэн хэрэглэгч | Тоо | 0 | 197 | 300 | 500 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |
| 3.1.4 | **Үйл ажиллагаа 3.1.4** Байгаль орчинд ээлтэй ногоон эрчим хүчний үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, энэ хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо, чадавхыг бэхжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр | Тоо | 0 | 0 | 2 | 4 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |
| 3.1.5 | **Үйл ажиллагаа 3.1.5** | Шалгуур үзүүлэлт | Хувь | 0 | 0 | 30 | 50 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Салбарын хэмжээнд ногоон ажлын байрны шалгуур үзүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж нэвтрүүлнэ. | нэвтрүүлсэн ААНБ | | | | | | | |
| 3.1.6 | **Үйл ажиллагаа 3.1.6** Салбарын шийдвэр гаргалтад байгаль хамгаалал, нутгийн уугуул эмэгтэй, эрэгтэй иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хийнэ. | Хуулийн өөрчлөлт | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ | ЖҮХ |
| 3.1.7 | **Үйл ажиллагаа 3.1.7** Гамшиг, эрсдэлийн үеийн арга хэмжээний тусгай төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийнэ. | Тусгай төлөвлөлт | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам | ОБЕГ, ЖҮХ |
| 3.1.8 | **Үйл ажиллагаа 3.1.8** Эрсдэлтэй/ гамшгийн нөхцөлд ажиллагчдын ажлын орчин нөхцөлд жендэрийн дүн шинжилгээ хийж, шинэ хэвийн нөхцөлд нийцүүлэх төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж хэрэгжүүлнэ. | Шинжилгээ | Тоо | 0 | 0 | 1 | | Эрчим хүчний яам | ОБЕГ, ЖҮХ |
| | | Удирдамжийн хэрэгжилт | Хувь | | | 30 | 50 | | |
| 3.1.9 | **Үйл ажиллагаа 3.1.9** Цар тахал зэрэг гамшгийн нөхцөлд хөдөлмөрийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалт гарахаас сэргийлэх, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангах чиглэлээр ЖҮХ-ний зөвлөмжийг хэрэгжүүлнэ. | Зөвлөмжийн хэрэгжилт | Хувь | 0 | 0 | 40 | 60 | Эрчим хүчний яам | ОБЕГ, ЖҮХ |
| **3.2** | **Зорилт 3.2. Хэрэглэгчдэд үйлчлэх бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ.** | **Тухайн хугацааны төлөвлөлтийн хэрэгжилт** | **Хувь** | **0** | **100** | **100** | **100** | **Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, НУБ** | **ЖҮХ, ОУБ** |
| 3.2.1 | **Үйл ажиллагаа 3.2.1** | Хууль тогтоомжийн өөрчлөлт | Тоо | 0 | 0 | 2 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ, ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хэрэглэгчдэд жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ. | | | | | | | |
| 3.2.2 | **Үйл ажиллагаа 3.2.2** Эмэгтэйчүүд, өрх толгойлсон эцэг, эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, эмзэг бүлгийн өрх, дотоодын шилжин ирэгч зэрэг нийгмийн бүлгүүдийн онцлогийг харгалзсан үйлчилгээг нэвтрүүлнэ. | Үйлчилгээний төрөл | Тоо | 0 | 0 | 1 | 2 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ЖҮХ, ОУБ |
| 3.2.3 | **Үйл ажиллагаа 3.2.3** Хөдөө, орон нутгийн орлого багатай, нийгмийн эмзэг бүлгийн айл өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж, хэрэглээг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ хэрэгжүүлсэн сумд | Тоо | 0 | 0 | 11 | 21 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ЖҮХ, ОУБ |
| 3.2.4 | **Үйл ажиллагаа 3.2.4** Гэр, байшинг стандартын дагуу дулаалж дулаан алдагдлыг бууруулах, улмаар эрчим хүч хэмнэх, хэрэглээний дадлын өөрчлөлт хийх чиглэлд өрх, ААНБ-тай хамтран ажиллах үйл ажиллагааг чанаржуулж, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна. | Үйл ажиллагааны төрөл | Тоо | 0 | 0 | 2 | 4 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ЖҮХ, ОУБ |
| 3.2.5 | **Үйл ажиллагаа 3.2.5** Иргэд, ААНБ-ын сэргээгдэх эрчим хүч ашиглах талаарх мэдлэг, хандлагыг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэхэд төрийн татвар, зээлийн болон эрх зүйн бусад бодлогоор дэмжиж, олон улсын сайн туршлагыг судлан, түгээн дэлгэрүүлнэ. | Хэвлэл, мэдээллийн бүтээгдэхүүн | Тоо | 0 | 2 | 2 | 2 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ЖҮХ, ОУБ |
| | | Үйл ажиллагааны төрөл | Тоо | 0 | 0 | 1 | 2 | | |
| 3.2.6 | **Үйл ажиллагаа 3.2.6** Бичил, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаа тогтвортой эрхлэхэд | Үйл ажиллагааны төрөл | Тоо | 0 | 1 | 1 | 2 | Эрчим хүчний яам, Цахилгаан дамжуулах, | МҮХАҮТ, МХ, ЖҮХ, ОУБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цахилгаан хангамжийн чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ. | Тусгай арга хэмжээ | Тоо | 0 | 0 | 1 | 1 | түгээх ТбХХ-ийн ААНБ, НУБ | |
| 3.2.7 | **Үйл ажиллагаа 3.2.7**<br>Журам, бүртгэлийн маягт зэрэгт үндэслэн хэрэглэгчийн судалгааг нарийвчлан гаргаж, үнэ тарифын ангилалд жендэрийн мэдрэмжтэй өгөгдөл тусгаж, хөнгөлөлттэй үнэ тогтоох, үнэ тэглэх зэрэгт нийгмийн бүлгүүд, эрэгтэй, эмэгтэй хүний ялгаатай хэрэгцээг тусгана. | Хэрэглэгчийн судалгаа, хүйсээр | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ЖҮХ, МҮЭХ |
| | | Арга хэмжээний төрөл | Тоо | 0 | 0 | 1 | 1 | | |
| 3.2.8 | **Үйл ажиллагаа 3.2.8**<br>Салбарын олон нийттэй харилцах, зар сурталчилгааны агуулгад жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт нэвтрүүлж, иргэдийн оролцооны механизм бий болгоно. | Хэрэгжүүлсэн байгууллага | Эзлэх хувь | 0 | 10 | 30 | 40 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ТбХХ-ийн ААНБ | ЖҮХ-ны дэргэдэх Хэвлэл мэдээллийн зөвлөл |
| | | Механизм | Тоо | 0 | 1 | | | | |
| 3.2.9 | **Үйл ажиллагаа 3.2.9**<br>Тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох бүртгэлд жендэрийн мэдрэмжтэй өгөгдөл тусгана. | Тусгасан өгөгдөл | Тоо | 0 | 0 | 1 | 2 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ТбХХ-ийн ААНБ, НЗБ | ЖҮХ |
| 3.2.10 | **Үйл ажиллагаа 3.2.10**<br>Салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн байгаль орчин, хүний эрх, нийгэм, эдийн засгийн нөлөөний үнэлгээг үндэсний, бүсийн, орон нутгийн, ААН, байгууллага, өрх гэрийн түвшинд болон нөлөөллийн бүсэд жендэрийн мэдрэмжтэй хийх аргачлалыг боловсруулан, нэвтрүүлнэ. | Аргачлал | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЖСЗ, ТбХХ-ийн ААНБ, НУБ | ХЭҮК, БОНБҮ-ний мэргэжлийн зөвлөл, ҮАААНБ, МХ, ТББ, ХО, ХБ |
| | | Нэвтрүүлсэн ААНБ | Хувь | 0 | 0 | 30 | 40 | | |
| 3.2.11 | **Үйл ажиллагаа 3.2.11**<br>Салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төлөвлөхдөө нөлөөллийн | Аргачлал | Тоо | 0 | 0 | 1 | 1 | Эрчим хүчний яам, ЭХЗХ, ЭХХЗ, ЖСЗ, | Салбарын эмэгтэйчүүдийн |
| | | Сургалтад хамрагдсан | Хувь | 0 | 0 | 30 | 50 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бусийн иргэдэд танилцуулах, санал авах ажиллагааг хүйсээр, насны бүлгээр дагнасан хэлбэрээр зохион байгуулах аргачлал боловсруулж, чадавхжуулна. | үнэлгээний компани, үнэлгээчин, шинжээч | | | | | | БОНБҮ-ний мэргэжлийн зөвлөл, ҮК, НЗБ, ТбХХ-ийн ААНБ | холбоо, МХ, ТББ, ХО, ХБ, ҮАААНБ |

**Товчилсон үгийн тайлбар:**

| | |
|---|---|
| ААН | Аж ахуйн нэгж |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АОМХ | Ажил олгогчдын мэргэжлийн холбоод |
| БТСУХ | Биеийн тамир, спортын улсын хороо |
| ГБХЗХГ | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| ЖМТ | Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт |
| ЖС | Жендэрийн стратеги |
| ЖҮХ | Жендэрийн үндэсний хороо |
| ЖСЗ | Жендэрийн салбар зөвлөл |
| ЖҮШБ | ЖҮХ-ны дэргэдэх Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг |
| ЖСХ | Жендэрт суурилсан хүчирхийлэл |
| ЖЭТБХтХ | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| МАхХ | Монголын ахмадын холбоо |
| МҮЭХ | Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| МХ | Мэргэжлийн холбоод |
| МХАЭБ | Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн байгууллага |
| МЭрХолбоо | Монголын эрэгтэйчүүдийн холбоо |
| НЗБ | Нутгийн захиргааны байгууллага |
| ЭХС | Эрчим хүчний сургууль |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| СУГ | Соёл урлагийн газар |
| ТАЗ | Төрийн албаны зөвлөл |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТбХХ-ийн | Төрийн ба хувийн хэвшлийн |
| ТМБСБ | Техникийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага |
| УАТ | Удирдах албан тушаалтан |
| ҮАААНБ | Үнэлгээ, аудитын ААНБ |
| ҮК | Үнэлгээний компани |
| ХАМ | Хүйсээр ангилсан мэдээлэл |
| ХБ | Хандивлагч байгууллага |
| ХМЗ | ЖҮХ-ны дэргэдэх Хэвлэл мэдээллийн зөвлөл |
| ХО | Хөрөнгө оруулагч |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| ХМБ | Хэвлэл мэдээллийн байгууллага |
| ШУТИС | Шинжлэх ухаан технологийн их сургууль |
| ЭШБ | Эрдэм шинжилгээний байгууллага |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЭХЗХ | Эрчим хүчний зохицуулах хороо |
| ЭХХЗ | Эрчим хүчний хэмнэлтийн зөвлөл |
| ЭХҮТ-СҮТ | Эрчим хүчний үндэсний төв-Сургалтын үндэсний төв |
| ЭСБ | ЖҮХ-ны дэргэдэх Эрдэмтэн судлаачдын бүлэг. |